




Цэвэрлэгээний материалын техникийн тодорхойлолт /Багц-1 Дотоодын үйлдвэрээс авах/

| Д.Д | Норматив бараа материал | Хэмжих нэгж | Тоо ширхэг | Техникийн тодорхойлолт | Жишиг зураг (дүйцэхүйц) |
|-----|--------------------------------|-------------|------------|---|---|
| 1 | Бүх төрлийн гадаргуу цэвэрлэгч | ширхэг | 1908 | Бүх төрлийн мод, гантиг, керамик хавтан, хогийн сав, плита, ванн, душ, угаалтуур, бохирын хоолой, хулдаас, резин, жорлонгийн суултуур гэх мэт хатуу гадаргуу дээр тогтсон бүх төрлийн толбо, тосыг хялбархан цэвэрлэж, гадаргууг гэмтээлгүй цэвэрлэдэг, хурдан бохирдохоос сэргийлэх чанартай, цэвэрлэсэн гадаргуу загалтаж цайрдаггүй, тааламжтай үнэр агуулсан, хүний биед ямар нэгэн харшил үүсгэдэггүй байх. 1л-ээс дээш хэмжээтэй савлагаатай байх |  |
| 2 | Гарын саван | ширхэг | 1152 | Арьс хуурайшуулахгүй, бактерийн эсрэг, харшил өгөхгүй, хир бохирдол арилгах үзүүлэлт өндөртэй, байгалийн гаралтай, тааламжтай үнэртэй байх. МУ-ын стандартад тохирсон, хатуу (75гр-с дээш хэмжээтэй), эсхүл шингэн (300мл-с дээш хэмжээтэй) |  |
| 3 | Дэрсэн шүүр | ширхэг | 16 | Эдэлгээ сайтай, модон урт иштэй, боодол чанга, сугарч ундаггүй байх |  |
| 4 | Хивс цэвэрлэгч | ширхэг | 222 | Хивс хивсэнцэр, зөөлөн тавилгын аливаа бохирдлыг цэвэрлэх зориулалттай шингэн цэвэрлэгээний бодис. 1л-с багагүй хэмжээгээр савлагдсан. |  |

| | | | | | |
|---|-------------------|--------|------|---|---|
| 5 | Хогны уут /жижиг/ | багц | 2112 | МУ-ын стандартад нийцсэн 3 микроны зузаантай, 20л багтаамжтай, 430*550мм хэмжээтэй, бат бөх зузаан, даац сайтай, сайн чанарын, 30-аас дээш ширхэгтэй, хар өнгийн, таславчтай байх. |  |
| 6 | Хогны уут/том/ | багц | 732 | МУ-ын стандартад нийцсэн 3 микроны зузаантай, 40л багтаамжтай, 680*550мм хэмжээтэй, бат бөх зузаан, даац сайтай, сайн чанарын, 30-аас дээш ширхэгтэй, хар өнгийн, таславчтай байх. |  |
| 7 | Шил цэвэрлэгч | ширхэг | 363 | Шил болон толины гадаргуу дээр тогтсон бохирдлыг арилгахаас гадна телевизор, компьютерийн монитор дээрх тоос, шороо, тос, утааны тортог зэргээс тогтсон бохирдлыг маш сайн цэвэрлэх үйлчилгээтэй, маш түргэн хугацаанд хатдаг байх, шүршдэг, шингэн, 500гр-аас багагүй савлагаатай байх |  |
| 8 | Эдийн саван | ширхэг | 4756 | Цэвэрлэгээний чанар хангахуйц, олон улсын стандартад бүрэн нийцсэн, шахалт сайтай, хир толбо маш сайн арилгадаг, хөөсрөлт сайн, харшил өгөхгүй байх. 230 гр-аас багагүй хэмжээтэй байх |  |